



НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“МСҮТ, ЕБС-ИЙН ДОТУУР БАЙР, ЦЭЦЭРЛЭГИЙН ХҮҮХДИЙН
ХООЛНЫ ЗАРДЛЫН ЗАРЦУУЛАЛТ, ҮР ДҮН”

**ХООЛНЫ ЗАРДЛЫН НОРМАТИВЫГ ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭ ХАНШТАЙ
УЯЛДУУЛЖ БАТЛААГҮЙГЭЭС ИЛЧЛЭГИЙГ БҮРЭН ХАНГАХ
БОЛОМЖГҮЙ БАЙНА.**

Аудитын код: ДГА-2020/03-НА



	Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Ариунаа Утас: 70522734 Цахим хаяг: dornogovi@audit.gov.mn
	Аудитын менежер: Ч.Хэрлэнчимэг Утас: 70523020 Цахим хаяг: kherlenchimegch@audit.gov.mn
	Ахлах аудитор: Э.Энхцэцэг Цахим хаяг: enkhtsetsege@audit.gov.mn
	Аудитор: Л.Равдандорж Цахим хаяг: ravdandorjl@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

2020 оны 06 сар

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар	4
Хүснэгтийн товъёог	5
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл	6-7

БҮЛЭГ А. Хоолны зардлын норматив нь зах зээлийн үнэ ханштай уялдаж батлагдаагүйгээс илчлэг нормыг хангуулж төлөвлөх нөхцөл бүрдэхгүй байна.

А.1. Хүүхдийн хоолны зардлын төсвийг бодит тоо, мэдээнд тулгуурлаж төлөвлөсөн боловч, хоолны илчлэг, нормыг хангах талаар тооцож төлөвлөөгүй байна.

А.1.1. Хоолны зардлыг өмнөх жилүүдийн хүүхдийн тооны бодит гүйцэтгэлд үндэслэж төлөвлөсөн байна.....8

А.1.2. Хоолны зардлыг илчлэг, үндсэн шимт бодисын зөвлөмжтэй уялдуулж төлөвлөөгүй байна.....8-9

А.2. Хоолны зардлын дундаж нормативыг тогтоохдоо зах зээлийн бодит үнэ, ханшид тулгуурлаж батлаагүйгээс батлагдсан төсөв нь илчлэг нормыг хангахад хүрэлцэхгүй байна.

А.2.1. Хүүхдийн хоолны зардлын норматив хэмжээг зах зээлийн үнэ ханш, хоногийн хэрэгцээг хангах хүнсний бүтээгдэхүүний жишиг хэмжээнд үндэслэж батлаагүй байна.....9-10

А.2.2. Хоолны илчлэг норм тогтоосон журмуудад тусгасан хоногийн хэрэгцээг хангах бүтээгдэхүүний хэмжээ өөр батлагдсанаас баримтлах чиглэл тодорхой бус байна.....10-12

БҮЛЭГ Б. МСҮТ, ЕБС-иудын дотуур байр, цэцэрлэгийн хүүхдийн хоолны материалын худалдан авалт, зарцуулалт нь илчлэг нормтой уялдаагүй байна.

Б.1. Хүнсний материал худалдан авах үйл ажиллагаанд хоолны илчлэг нормын асуудлыг орхигдуулсан байна.

Б.1.1. Хоолны технологи карт, цэсийг хоногийн хоол хүнсээр авбал зохих бодисын зөвлөмжтэй уялдуулж боловсруулаагүй байна.....12-13

Б.1.2. Шаардлагатай хүнсний материалын тоо хэмжээг хоолны технологи карт, цэсэд үндэслэж тооцдоггүй байна.....13

Б.1.3. Хоол, хүнсний материалыг худалдан авахдаа илчлэг нормын хэмжээг харгалзахгүй байна.....13-14

Б.2. Хүүхдийг хоол хүнсээр хангахдаа норматив хэмжээнд багтаан батлагдсан төсвийг бүрэн зарцуулахгүй байна.

Б.2.1. Хоолны зардлыг цэс, технологийн картын дагуу зарцуулж байгаа байдалд тавих хяналт орхигдсоноос нийтлэг зөрчлүүд гарсан байна.....14-15

Б.2.2. Нийт хоолны зардлын 20 хувь буюу 318,5 сая төгрөгийн хэмнэлтийг бусад зардалд шилжүүлэн зарцуулж, үүний 9 хувийг зориулалт бусаар зарцуулсан байна.....15-17

БҮЛЭГ В. Орон нутгийн удирдлага, мэргэжлийн байгууллагаас хүүхдийн хоол үйлдвэрлэлийг чанаржуулах талаар мэргэжил арга зүйгээр хангаж ажиллах шаардлагатай байна.

В.1. Хүүхдийн хоолны илчлэг, норм, орц, чанар байдалд тавих хяналт хангалтгүй байна.

В.1.1. Мэргэжлийн байгууллагуудаас хэрэгжүүлсэн хяналт шалгалтын үр дүн тодорхой бус байна.....17-18

В.1.2. Аймаг, сумын Засаг дарга, БСУГ-аас хүүхдийн зохистой хооллолтын талаар ажил зохион байгуулаагүй байна.....18

В.2. Хүүхдийн хоолны илчлэг, норм, орц, чанар байдлыг сайжруулах талаар хийх ажлын чиглэл тодорхойгүй байна.

В.2.1. Мэргэжлийн байгууллагууд хяналт шалгалт хийж байгаа боловч үр дүнг сайжруулах чиглэл өгөөгүй байна.....18

В.2.2. Хүүхдийн хоолны орц, хоногт авах илчлэгийн асуудлаар эцэг, эхчүүдээс санал, гомдол ирүүлээгүй байна.....19

ДҮГНЭЛТ:.....20-21

ЗӨВЛӨМЖ:22-23

Саналд өгсөн тайлбар:.....

Тайлбар

Товчилсон үгийн тайлбар

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
МУ	Монгол улс
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
МСҮТ	Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв
МХГ	Мэргэжлийн хяналтын газар
БСУГ	Боловсрол, соёл урлагийн газар
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЭМГ	Эрүүл мэндийн газар
БСШУСС	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд
ЭМС	Эрүүл мэндийн сайд
ХХААХҮС	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд
ЗГ	Засгийн газар
ХЗДХС	Хууль зүй, дотоод хэргийн сайд
БСШУСЯ	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар

Хүснэгтийн товъёог:

№	Тайлбар	Хуудасны дугаар
<i>Хүснэгт 1</i>	<i>Хоолны зардлын норматив тогтоосон тогтоолууд</i>	<i>9</i>
<i>Хүснэгт 2</i>	<i>Норматив зардлаас хэтрүүлсэн зардлын судалгаа</i>	<i>14</i>
<i>Хүснэгт 3</i>	<i>Норматив зардлын хэмнэлтийн судалгаа</i>	<i>16</i>

Дүрслэлийн товъёог:

№	Тайлбар	Хуудасны дугаар
<i>Дүрслэл 1</i>	<i>Хоолны илчлэг норм тогтоосон журмууд</i>	<i>11</i>

Графикийн товъёог:

№	Тайлбар	Хуудасны дугаар
<i>График 1</i>	<i>Аудитад хамрагдсан байгууллагын тоо</i>	<i>8</i>
<i>График 2</i>	<i>Хүүхдийн тоо</i>	<i>8</i>
<i>График 3</i>	<i>Норматив зардлыг зах зээлийн үнэ ханштай харьцуулсан судалгаа</i>	<i>9</i>
<i>График 4</i>	<i>Зах зээлийн үнэ ханшийн судалгаа</i>	<i>10</i>
<i>График 5</i>	<i>Хоолны зардлын гүйцэтгэл</i>	<i>16</i>
<i>График 6</i>	<i>Хоолны зардлаас бусад зардалд шилжүүлэн зарцуулсан судалгаа</i>	<i>16</i>

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Төрийн аудитын тухай хуулийн 10 дугаар зүйл, МУ-ын Ерөнхий аудиторовын 2020 оны А/53 дугаар тушаалаар батлагдсан аудитын сэдэв, аймгийн ИТХ-ын захиалга, Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу хийж гүйцэтгэлээ.

Аудитын зорилт

Монгол Улсад мөрдөгдөж буй дотуур байр, цэцэрлэгийн хүүхдийн хоногийн хоол хүнсээр авбал зохих илчлэг норм, зөвлөмж хэмжээ, хоолны зардлын дундаж норматив баталсан тогтоол, журмуудын хэрэгжилтэд нийцлийн аудит хийж, дүгнэлт гарган, зөвлөмж боловсруулж, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулан, иргэд олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдлээ.

Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- Хоолны зардлын төлөвлөлт нь мөрдөгдөж байгаа журамд заасан илчлэг нормыг хангасан эсэх.
- МСҮТ, ЕБС-иудын дотуур байр, цэцэрлэгийн хүүхдийн хоолны материалын худалдан авалт, зарцуулалт нь илчлэг нормтой уялдсан эсэх.
- Мэргэжлийн байгууллага, орон нутгийн удирдлагууд хууль, журамд заасан эрх, үүргээ хэрэгжүүлсэн эсэх.

Аудитын хамарсан хүрээ

Аудитад аймгийн МСҮТ, ЕБ-ын 8 сургууль, 22 хүүхдийн цэцэрлэгийн 2018-2019 оны хичээлийн жил, аймгийн ЗДТГ, Сайншанд, Замын Үүд сумдын ЗДТГ, МХГ, БСУГ, ЭМГ, хүнсний материал нийлүүлэгч аж ахуйн нэгж байгууллага, иргэд болон бусад холбогдох байгууллагуудын үйл ажиллагааг хамрууллаа.

Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 4000-4200, Монгол Улсын Төрийн аудитын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2016 оны А/146 дугаар тушаалаар батлагдсан “Нийцлийн аудитын түр журам”-ыг баримтлан шалгагдагч байгууллагын холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга, лавлагаа, судалгаа авах, анхан шатны баримт, журналтай тулгаж, цуглуулсан баримт материалд дүн шинжилгээ хийх, харьцуулах, нэгтгэх зэрэг горимыг хэрэгжүүлэх зэрэг арга зүйг ашиглан, аудитын судалгаа, хөтөлбөр, горимын дагуу нотлох зүйл цуглуулж дүгнэлт гаргалаа.

Аудитын зорилттой холбоотой дараах хууль, дүрэм, журам, зааврыг аудитын шалгуур үзүүлэлт болгон ашиглав. Үүнд:

- Эрүүл мэндийн тухай хууль
- Боловсролын тухай хууль
- Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль
- Засгийн газрын 2012 оны 106 дугаар тогтоол
- Засгийн газрын 2017 оны 162 дугаар тогтоол
- Засгийн газрын 2019 оны 450 дугаар тогтоол

**Аудитын
бүрэлдэхүүн,
хугацаа**

- Засгийн газрын 2020 оны 83 дугаар тогтоол
- Эрүүл мэндийн сайдын 2014 оны 113 дугаар тушаал
- Эрүүл мэндийн сайдын 2016 оны 207 дугаар тушаал
- Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/74 дүгээр тушаал
- БСШУСС, ЭМС-ын хамтарсан 2018 оны А/448, А/268 дугаар тушаал
- Засгийн газрын 2016 оны 242 дугаар тогтоол
- ХХААХҮС-ын 2010 оны 206 дугаар тушаал
- Бусад холбогдох эрх зүйн актууд

Аудитын төлөвлөгөөг 2020 оны 05 дугаар сарын 28-ны өдөр батлуулж, гүйцэтгэлийн болон тайлагналын үе шатны ажлыг 2020 оны 06 дугаар сарын 24-ний өдрийг хүртэлх хугацаанд ахлах аудитор Э.Энхцэцэг, аудитор Л.Равдандорж нар хэрэгжүүлэн, аудитыг дарга, тэргүүлэх аудитор Ч.Ариунаа удирдаж, аудитын менежер Ч.Хэрлэнчимэг аудитын стандарт, арга зүйн дагуу үе шатны хяналтыг хэрэгжүүлсэн.


Аудитын тайлан, судалгааг 2020 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн дотор нэгтгэн, аудитын тайланг холбогдох үе шатны хяналтаар баталгаажуулж, 2020 оны 06 дугаар сарын 30-ны дотор Үндэсний аудитын газар болон холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлнэ.

БҮЛЭГ А. Хоолны зардлын норматив нь зах зээлийн үнэ ханштай уялдаж батлагдаагүйгээс илчлэг нормыг хангуулж төлөвлөх нөхцөл бүрдэхгүй байна.

Үндсэн мэдээлэл

Аймгийн хэмжээнд 2018-2019 оны хичээлийн жилд МСҮТ 1, 20 ЕБС, 31 цэцэрлэг үйл ажиллагаа явуулж, ЕБС-ийн дотуур байранд нийт 785 хүүхэд амьдарч, цэцэрлэгт 4909 хүүхэд хамрагдсан байна.

Аудитаар стандарт хүснэгтийг ашиглан нийт 47 байгууллагаас магадлалын түүврээр 33 байгууллагын түүвэрлэж, 2018-2019 оны хичээлийн жилийн үйл ажиллагааг хамрууллаа.



А.1. Хүүхдийн хоолны зардлын төсвийг бодит тоо, мэдээнд тулгуурлаж төлөвлөсөн боловч, хоолны илчлэг, нормыг хангах талаар тооцож төлөвлөөгүй байна.

А.1.1. Хоолны зардлыг өмнөх жилүүдийн хүүхдийн тооны бодит гүйцэтгэлд үндэслэж төлөвлөсөн байна.

МУ-ын Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.1-т “Төсвийн төвлөрүүлэн захирагчид харьяалагддаг төсвийн шууд захирагч нь жилийн төсвийн төслөө жил бүрийн 07 дугаар сарын 25-ны дотор харьяалах төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэх” гэж заасны дагуу аудитад хамрагдсан байгууллагууд төсвийн төслийг бэлтгэсэн байна.

Аймгийн боловсролын салбарын статистик мэдээгээр аудитад хамрагдсан байгууллагуудын сүүлийн гурван хичээлийн жилийн хүүхдийн дундаж тоо 4971 байхад төсвийн төсөлд ЕБС-ийн дотуур байр, цэцэрлэгт хамрагдах хүүхдийн тоог 5139 байхаар төлөвлөж хүргүүлснээс 5055 хүүхдэд ноогдох хоолны зардал батлагдсан байна.

Байгууллагууд төсвийн төсөлд хүүхдийн тоог аймгийн БСУГ-ын статистик мэдээ болон хүчин чадалд үндэслэж төлөвлөдөг байна.

А.1.2. Хоолны зардлыг илчлэг, үндсэн шимт бодисын зөвлөмжтэй уялдуулж төлөвлөөгүй байна.

Төсвийн төслийг боловсруулахдаа ЗГ-ын 2012 оны 106 дугаар тогтоолоор баталсан ЕБС, мэргэжлийн боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагын дотуур байранд амьдрах нэг хүүхэд, цэцэрлэгийн хүүхэд бүрийн өдрийн хоолны зардлын дундаж норматив, хүүхдийн тооны дундаж үзүүлэлтэд тулгуурлан төлөвлөсөн байна.

Дээрх төлөвлөсөн хоолны зардал нь тухайн хичээлийн жилд цэцэрлэг, ЕБС-ийн хүүхдийн хоногийн хэрэгцээг хангах хүнсний бүтээгдэхүүний жишиг хэмжээ, хоногийн хоол хүнсээр авбал зохих илчлэг, үндсэн шимт бодис, аминдэм, эрдэс бодисын хэмжээг бүрэн хангахад хүрэлцэх эсэх талаар тооцоо судалгаа хийж төлөвлөдөггүй байна.

А.2. Хоолны зардлын дундаж нормативыг тогтоохдоо зах зээлийн бодит үнэ, ханшид тулгуурлаж батлаагүйгээс батлагдсан төсөв нь илчлэг нормыг хангахад хүрэлцэхгүй байна.


А.2.1. Хүүхдийн хоолны зардлын норматив хэмжээг зах зээлийн үнэ ханш, хоногийн хэрэгцээг хангах хүнсний бүтээгдэхүүний жишиг хэмжээнд үндэслэж батлаагүй байна.

ЕБС, мэргэжлийн боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагын дотуур байрны болон цэцэрлэгийн хүүхэд бүрийн нэг өдрийн хоолны зардлыг дараах байдлаар тогтоож, мөрдсөн байна.

Хүснэгт №1

Хоолны зардлын дундаж норматив баталсан шийдвэрийн нэр	ЗГ-ын 2012.10.27-106	ЗГ-ын 2019.12.18-450	ЗГ-ын 2020.03.04-83
Цэцэрлэг	1650	2475	
ЕБС-ийн дотуур байр	2315	3475	
МСҮТ-ийн дотуур байр	2315		3000

Засгийн газрын 2012 оны 106, 2019 оны 450, 2020 оны 83 дугаар тогтоолуудаар батлагдсан хоолны зардлын нормативыг хүүхдийн хоногийн хэрэгцээг хангах хүнсний бүтээгдэхүүний жишгийн тухайн оны статистик мэдээний зах зээлийн үнэ ханштай харьцуулж үзэхэд дараах байдалтай байна.




Тухайлбал: Засгийн газрын 2012 оны 106 дугаар тогтоолоор батлагдсан хоолны зардлын норматив нь хүүхдийн хоногийн хэрэгцээг хангах хүнсний бүтээгдэхүүний жишиг хэмжээний дунджаар 52 хувийг хангахаар байна.

Тус тогтоолд өөрчлөлт оруулж Засгийн газрын 2019 оны 450, 2020 оны 83 тогтоолуудаар хоолны зардлын норматив хэмжээг шинэчлэн баталсан байх боловч өөрчилсөн норматив нь хүүхдийн хүнсний бүтээгдэхүүний жишиг хэмжээний цэцэрлэгт бүрэн, ЕБС-ийн дотуур байранд 72, МСҮТ-ийн дотуур байрны хүүхдийн 55 хувийг хангахуйц хэмжээнд батлагдсан байна.

Монгол Улсын хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний 2012 оноос хойш хугацааны зах зээлийн үнэ ханшийн судалгаанаас цэцэрлэг, сургуулиудад нийтлэг хэрэглэгддэг дараах 6 нэрийн хүнсний бүтээгдэхүүний үнийг авч үзэхэд мах 43,2, гурил 55,9, будаа 107,8, шингэн сүү 44,7, элсэн чихэр 60,2 хувиар тус тус өссөн байхад Засгийн газрын 2019 оны 450 тогтоолоор баталсан хоолны зардлын норматив хэмжээг хуучин нормативаас 50 хувь, 2020 оны 83 дугаар тогтоолоор шинэчлэн баталсан норматив нь өмнөх зардлын нормативаас 29 хувиар тус тус нэмэгдүүлэн баталсан байна.


График №4



Дээрх харьцуулалтаас харахад хоолны зардлын дундаж норматив хэмжээг хүнсний бүтээгдэхүүний зах зээлийн үнийн өсөлттэй уялдуулан тооцож батлаагүйгээс цэцэрлэг, сургуулийн дотуур байрны хүүхдийн хоногийн хэрэгцээг хангах хүнсний бүтээгдэхүүний жишгийг баримтлах боломжгүй байна.

А.2.2. Хоолны илчлэг норм тогтоосон журмуудад тусгасан хоногийн хэрэгцээг хангах бүтээгдэхүүний хэмжээ өөр батлагдсанаас баримтлах чиглэл тодорхой бус байна.

Боловсролын салбарын хэмжээнд хоолны илчлэг норм тогтоосон дараах журмуудыг мөрдөж байна.



ЭМС-ын 2014 оны 113 дугаар тушаалаар цэцэрлэг, сургуулийн насны хүүхдийн хэрэгцээт илчлэг, хоногийн хоолны хэмжээ, 1-18 насны хүүхдийн хоногийн хэрэгцээг хангах хүнсний бүтээгдэхүүний жишиг хэмжээ, хүнсний бүтээгдэхүүнийг хоолонд зориулан боловсруулахад гарах хорогдлын хэмжээг тус тус баталсан байна.

Харин ЭМС-ын 2017 оны А/74 дүгээр тушаалаар Монгол хүний бие махбодын хэвийн үйл ажиллагаа, өсөлт хөгжилтийг хангах, илч зарцуулалтыг нөхөхөд шаардагдах хоногийн хоол хүнсээр авбал зохих илчлэг, үндсэн шимт бодисын зөвлөмж хэмжээ, хоногийн хоол хүнсээр авбал зохих аминдэмийн зөвлөмж хэмжээ, эрдэс бодисын зөвлөмж хэмжээ, жишсэн дундаж хүний илчлэгийн хоногийн зөвлөмж хэмжээг хангах хүнсний бүтээгдэхүүний жишиг хэмжээ, орлуулан хэрэглэх хүнсний бүтээгдэхүүний жагсаалтыг тус тус баталсан байна.

БСШУСС, ЭМС-ын хамтарсан 2018 оны А/448, А/268 тушаалаар цэцэрлэг, ЕБС-ийн хүүхдийн хоногийн хоолны хэмжээ, хоногийн хэрэгцээг хангах хүнсний бүтээгдэхүүний жишиг хэмжээ, хүүхдийн хоол үйлчилгээнд хэрэглэх хоол, хүнсний бүтээгдэхүүн дэх давс, чихэр, тосны агууламжийн зөвшөөрөгдөх дээд хэмжээг тус тус баталсан байна.

Дээрх журмуудад тусгагдсан ялгаатай нөхцөлүүдийг авч үзвэл:

ЭМС-ын 2014 оны 113 дугаар тушаал → 1-18 насны хүүхдийн хоногийн хэрэгцээг хангах хүнсний бүтээгдэхүүний жишиг хэмжээ, хүнсний бүтээгдэхүүний хорогдлын хэмжээ

ЭМС-ын 2017 оны А/74 дүгээр тушаал → жишсэн дундаж хүний илчлэгийн хоногийн зөвлөмж хэмжээг хангах хүнсний бүтээгдэхүүний жишиг хэмжээ, орлуулан хэрэглэх хүнсний бүтээгдэхүүний жагсаалт

БСШУСС, ЭМС-ын хамтарсан 2018 оны А/448, А/268 тушаал → хүүхдийн хоногийн хоолны хэмжээ, хүнсний бүтээгдэхүүн дэх давс, чихэр, тосны агууламжийн зөвшөөрөгдөх дээд хэмжээг баталсан байна.

БСШУСС, ЭМС-ын хамтарсан 2018 оны А/448, А/268 тушаалын 1 дүгээр хавсралтын 5-д “Цэцэрлэг, ЕБС-ийн хүүхдийн хоногийн хоолны үндсэн шимт бодис, илчлэгийн хэрэгцээг ЭМС-ын 2017 оны А/74 тоот тушаалыг мөрдөнө” гэж заасан байна.

Мөн ЭМС-ын 2019.01.18-ны өдрийн А/16 тоот “Тушаал хүчингүй болгох тухай” тушаалаар “ХЗДХС-ын 2018 оны дүгнэлт хүргүүлэх тухай 1-1/3881 тоот албан

бичгээр цэцэрлэг, сургуулийн хүүхдийн хоногийн хэрэгцээг хангах хүнсний бүтээгдэхүүний жишиг хэмжээг батлах тухай А/448, А/268 дугаар хамтарсан тушаалыг хуульд нийцүүлэн дахин баталж, хянуулж бүртгүүлэхээр ирүүлэх нь зүйтэй гэсэн дүгнэлт ирүүлсэн тул ЭМС-ын 2013 оны 207 дугаар тушаалын II хавсралтаар батлагдсан *ЭМС-ын 2014 оны 113 дугаар тушаалаар хүчингүй болгосон/ өмнөх* болон сургуулийн дотуур байранд хамрагдаж буй хүүхдэд хоногт авбал зохих хүнсний бүтээгдэхүүн, үндсэн шимт бодис ба илчлэгийн хэмжээг сэргээн мөрдсүгэй” гэсэн байна.

Салбарын сайдууд боловсролын салбарын хэмжээнд хүүхдийн хоолны илчлэг нормтой холбоотой мөрдөгдөж байгаа баталсан журмуудын хэрэгжилтийг хангаж ажиллах чиг үүргийг хүргүүлж байгаа ч дээрх журмууд нь уялдаа холбоогүй, өмнө батлагдсан ижил агуулгатай журмуудыг хүчингүй болгоогүйгээс орон нутгийн байгууллагуудад баримтлах чиглэл тодорхой бус байна.

Тухайлбал БСШУСЯ-ны 2019.10.11-ний 5/8982 тоот “Зөвлөмж хүргүүлэх тухай” албан бичгийн 3-т “ЭМС-ын Монгол хүүхдийн хоол тэжээлийн бодисуудын зөвлөмж хэмжээг батлах тухай 2014 оны 113 дугаар тушаалыг мөрдөж ажиллах” гэсэн зөвлөмж ирүүлсэн байхад аймгийн БСУГ-ын 2020.01.28-ны өдрийн 16 тоот албан бичгээр “ЭМС-ын 2017 оны А/74 тоот тушаалыг хэрэгжүүлж ажиллах талаар харьяа байгууллагуудтай хамтран сургалт зохион байгуулж ажиллах талаар чиглэл хүргүүлсэн байна.

БҮЛЭГ Б. МСҮТ, ЕБС-иудын дотуур байр, цэцэрлэгийн хүүхдийн хоолны материалын худалдан авалт, зарцуулалт нь илчлэг нормтой уялдаагүй байна.

Хүүхдийн бие бялдар, сэтгэхүй, дотоод эрхтний тогтолцоо нь өсөж хөгжихөд хангалттай хэмжээний эрүүл ахуйн шаардлага хангасан шим тэжээлийн бодисоор хангагдах нь нэн чухал асуудал байдаг.

Хангалттай шим тэжээлийг авч чадахгүйгээс хүүхдийн хэвийн өсөлт хөгжилт саатах, дархлаа сулрах, өвчлөмтгий болох, сэтгэн бодох чадвар удаашрах, зэрэг эрсдэлийг нэмэгдүүлдэг талаар эрүүл мэндийн байгууллагаас онцлон зөвлөдөг байна.

Б.1. Хүнсний материал худалдан авах үйл ажиллагаанд хоолны илчлэг нормын асуудлыг орхигдуулсан байна.

Б.1.1. Хоолны технологи карт, цэсийг хоногийн хоол хүнсээр авбал зохих бодисын зөвлөмжтэй уялдуулж боловсруулаагүй байна.

МУ-ын MNS:4946:2019 “Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газарт тавигдах ерөнхий шаардлага” стандартын 11.1-т “Хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд мөрдөх халуун, хүйтэн хоол, ундааны технологи картыг боловсруулан баталж, мөрдөж ажиллана”, 11.2-т “Хоолны цэс дээр хоолны шим тэжээлийн мэдээлэл, давсны агууламжийг тавьсан байна. Илчлэгийг химийн найрлагын хүснэгтийг ашиглан тооцооны аргаар тооцоолох болон итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлж, баталгаажуулна”, ХХААХҮС-ын 2010 оны 206 тоот “Хоолны газрын нийтлэг журам-ын 5.1-т “Тухайн хоолны үйлчилгээний ангилал, зэрэглэл, онцлогоос хамааруулан хоол, ундааны жор, технологи цэсийг боловсруулж, байгууллагын удирдлагаар баталгаажуулсан цэсээр хоол, бүтээгдэхүүний жор, технологийг баримтлан үйлдвэрлэл явуулна” гэж заасан.

Аудитад хамрагдсан нийт байгууллагууд хоолны цэсийг хүүхдийн хоногийн хоолны илчлэг, хүнсний бүтээгдэхүүний хоногийн жишиг хэмжээтэй уялдуулж боловсруулаагүй, технологи картыг хоолны амт чанар, илчлэгийг хангах, хүүхдийн эрүүл мэнд, өсөлт хөгжилд эерэг нөлөөлөхүйц байдалд чиглүүлээгүй, нэр төдий боловсруулсан байна.

МСҮТ, ЕБС-ийн дотуур байр, цэцэрлэгүүдийн хоолны үйлчилгээнд боловсруулан мөрдөж байгаа технологи картад тусгагдсан бүтээгдэхүүний орц хэмжээг журмаар баталсан хүүхдийн хоногийн хэрэгцээг хангах хүнсний бүтээгдэхүүний жишигт заасан илчлэгтэй харьцуулахад хангалттай хэмжээнд боловсруулаагүй байна. Тухайлбал зарим байгууллагуудын боловсруулсан технологи картад тусгагдсан илчлэгийг авч үзэхэд Сайншанд сумын 11 дүгээр цэцэрлэгийн өдрийн хоолны цэсэд тусгагдсан хоолнуудын технологи карт дахь илчлэг дунджаар 592 ккал /1670/, Мандах сумын ЕБС-ийн дотуур байр 1025 ккал /2399/, МСҮТ 786 ккал /2662/ илчлэгийг агуулсан байна.

Аудитад хамрагдсан байгууллагуудын 2018-2019 оны хичээлийн жилийн хүнсний материалын зарцуулалтын тайлангаас 1 хүүхдэд ногдох норматив зардал нь хамгийн өндөр болон бага саруудыг сонгож, 2 долоо хоногийн цэсийг авч үзэхэд нийт 1045 хоол тусгагдсанаас 338 хоолны технологи карт боловсруулагдаагүй байна.

Б.1.2. Шаардлагатай хүнсний материалын тоо хэмжээг хоолны технологи карт, цэсэд үндэслэж тооцдоггүй байна.

Аудитын түүвэрт хамрагдсан байгууллагууд нь 2018-2019 оны хичээлийн жилд шаардагдах хоол, хүнсний бүтээгдэхүүний нийт хэмжээг байгууллагын удирдлагаар батлуулсан цэсэд тусгагдсан хоолны нэр төрөл, технологи картын орц хэмжээ, хүүхдийн дундаж тоо зэрэгт үндэслэж тооцоолоогүй, батлагдсан төсвөөр зардлыг тооцож худалдан авах ажиллагаа зохион байгуулах байгууллагад санал хүргүүлсэн байна.

Аудитад хамрагдсан байгууллагын удирдлага, санхүүгийн ажилтнууд, тогооч, байрны багш нараас тус асуудлын талаар асуулга авахад 2 байгууллага батлагдсан төсвийн зардлаар, 3 байгууллага хоолны цэс, технологийн картад тусгагдсан орцод үндэслээгүй, бусад байгууллагууд үндэслэсэн гэх боловч тооцоолол хийж хүргүүлсэн талаар нотлох баримт байхгүй байна.

Хичээлийн жилд шаардлагатай хүнсний материалын тоо хэмжээг, технологийн карт, хоолны цэсэд тулгуурлахгүй зөвхөн батлагдсан төсвөөр тооцсоноос технологи картад тусгагдаагүй материал зарцуулах, цэсэд тусгагдаагүй хоол хийснээр хүүхдэд орц норм, илчлэг хангагдаагүй, баталгаагүй хоол хүнсийг өгөх эрсдэл үүссэн байна.

Б.1.3. Хоол, хүнсний материалыг худалдан авахдаа илчлэг нормын хэмжээг харгалзахгүй байна.

Сайншанд сумын түүвэрт хамрагдсан байгууллагуудын 2018-2019 оны хичээлийн жилийн хоол хүнсний бүтээгдэхүүн худалдан авах ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог аймгийн Засаг даргын 2018.06.26-ны өдрийн А/509 тоот захирамжаар байгуулж, ОНӨГ зохион байгуулсан байх боловч тус худалдан авах ажиллагаатай холбоотой баримт материал архивлагдаагүй, 2019-2020 оны хичээлийн жилийн худалдан авах ажиллагааг Сайншанд сумын ЗДТГ хариуцан зохион байгуулсан байна.

Бусад сумдад худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй, нийлүүлэгч аж ахуйн нэгж байгууллагуудтай шууд гэрээ байгуулсан байх ба гэрээний хавсралтад худалдан авах хүнсний бүтээгдэхүүний нэр төрөл, нэг бүрийн үнийг жагсаалтаар хавсаргасан боловч илчлэг нормтой худалдан авах материалын хэмжээг уялдуулж тооцоогүй байна.

Шалгагдагч байгууллагуудын хүнсний бүтээгдэхүүн худалдан авах гэрээ, бусад холбогдох материалуудыг үзэхэд:

- Хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээнд "... тухайн үеийн зах зээлийн үнээс хямд үнээр нийлүүлнэ" гэсэн тодорхой бус заалтыг оруулсан нь бүтээгдэхүүний үнэ ханшид хяналт тавих боломжгүй байдлыг үүсгэсэн,
- Тендерт шалгарсан аж ахуйн нэгж, байгууллагуудтай байгуулсан гэрээнд нийлүүлэх үнийг 1 удаа өөрчлөх тухай заалт оруулсан нь нийлүүлэгч байгууллагад давуу байдал үүсгэж, бүтээгдэхүүний үнийг хэт өндрөөр нийлүүлэх нөхцөлийг үүсгэсэн,
- Сайншанд сумын боловсролын салбарын бүх байгууллагуудын худалдан авах ажиллагааг 1 байгууллага хариуцан төвлөрүүлж зохион байгуулж байгаа нь нийлүүлэгчийг сонгон шалгаруулах хугацаа хойшлогдох, чадавхыг бүрэн үнэлж шалгаруулаагүйгээс бүтээгдэхүүний нийлүүлэлт удаашрах, батлагдсан цэсийн дагуу хоол олгох боломжгүй байдал үүсдэг байна.

Б.2. Хүүхдийг хоол хүнсээр хангахдаа норматив хэмжээнд багтаан батлагдсан төсвийг бүрэн зарцуулахгүй байна.

Б.2.1. Хоолны зардлыг цэс, технологийн картын дагуу зарцуулж байгаа байдалд тавих хяналт орхигдсоноос нийтлэг зөрчлүүд гарсан байна.

Аудитад хамрагдсан байгууллагуудын 2018-2019 оны хичээлийн жилийн хүнсний материалын зарцуулалтын тайлангаас 1 хүүхдэд ногдох норматив зардал нь хамгийн өндөр болон бага саруудыг сонгож, сонгогдсон саруудын хүнсний материалын зарцуулалтыг батлагдсан технологи карт, хоолны цэсийн дагуу хүүхдийн ирц, норматив зардалтай уялдуулж зарцуулсан байдлыг авч үзэхэд дараах нийтлэг зөрчил илэрлээ. Үүнд:

- Багшийн журнал болон нярвын тайланд бичигдсэн хүүхдийн ирц зөрүүтэй, үүнд холбогдох албан тушаалтнууд тухай бүр хяналт тавиагүй /Сайншанд сумын 1, 2, 6, 7, 10 дугаар цэцэрлэг, Хатанбулаг, Иххэт, Улаанбадрах сумын цэцэрлэг, Даланжаргалан сумын ЕБС-ийн дотуур байр/,
- Нэг хүүхдэд ногдох хоолны зардлын нормативыг нэмэгдүүлэн зарцуулж, батлагдсан төсвийг хэтрүүлсэн,

		Хүснэгт №2
№	Байгууллагын нэр	Нормативаас хэтрүүлсэн зардлын дүн /мян.төг/
1	Айраг сумын ЕБС-ийн дотуур байр	535,7
2	Айраг сумын цэцэрлэг	1429,4
3	Даланжаргалан сумын ЕБС-ын дотуур байр	168,8
4	Мандах ЕБС-ийн дотуур байр	85,7
5	Иххэт сумын цэцэрлэг	1253,4
6	Хатанбулаг сумын цэцэрлэг	517,2
7	Сайншанд сумын ЕБ-ын I сургууль	5878,5
8	Сайншанд сумын I цэцэрлэг	330,9
9	Сайншанд II цэцэрлэг	112,1
10	Сайншанд III цэцэрлэг	391,2
11	Сайншанд IV цэцэрлэг	2327,9
12	Сайншанд VI цэцэрлэг	903,5
13	Сайншанд VII цэцэрлэг	309,5
14	Сайншанд XII цэцэрлэг	418,1
15	Замын Үүд сумын II цэцэрлэг	106,1
Нийт дүн		14768,0

- Сайншанд сумын I сургууль, Хөвсгөл, Хатанбулаг сумдын ЕБС-ийн дотуур байрны багш нь хүүхдийн ирцийн журнал огт хөтлөөгүй,
- Даланжаргалан сумын ЕБС-ийн дотуур байр хоолны цэс баталж мөрдөөгүй, Сайншанд сумын VII цэцэрлэг 2018.12 сард, Сайншанд сумын ЕБ-ын III сургууль 2019.02 дугаар сар, Улаанбадрах сумын цэцэрлэгийн нүүдлийн анги 2019.06 сард хоолны цэс боловсруулаагүй,
- Сайншанд сумын 10 дугаар цэцэрлэгийн нярав ирцийн нэгтгэлийг зөрүүтэй тооцсон, ангийн багш нар журналд 2019.05 дугаар сарын ирцийг нэгтгээгүй,
- Хоолны цэсэд технологийн карт боловсруулаагүй хоолны нэр төрлийг тусгаж, хүнсний материал зарцуулсан,
- Технологийн картад цөөн нэр төрлийн материал тусгаж боловсруулснаас шаардах хуудсаар картад тусгагдаагүй материал зарцуулсан,
- Байгууллагуудын боловсруулсан хоолны цэсэд нэг хүүхдэд өдөрт өгөх хоолны тоо харилцан адилгүй тусгагдсан. Тухайлбал, ЕБС-ийн дотуур байрууд хоолны цэсэд өдөрт 6-7 төрлийн хоол, шингэн зүйл тусгаж өгсөн байхад Хатанбулаг сумын ЕБС-ийн дотуур байр өдөрт хүүхдэд 2 нэр төрлийн хоол тусгаж олгосон,
- БСШУСС, ЭМС-ын хамтарсан 2018 оны А/448, А/268 тушаалын 4 дүгээр хавсралтад заасан хүүхдийн хоол үйлдвэрлэлд хориглох хүнсний бүтээгдэхүүнийг хүүхдэд олгосон байна. Тухайлбал, маргарин болон чихэртэй түрхлэгтэй талх, шоколадны крем, найруулдаг цай гэх мэт.
- Хүүхдийн хоолонд хэрчсэн гурил, төрөл бүрийн гоймон, үйлдвэрийн боорцог, жигнэмэг, савлагдсан аарц, шүүс, хуурай сүү зэрэг бэлэн бүтээгдэхүүнийг өдөр тутмын хүнсэнд хэрэглэсэн байна.


Аудитад хамрагдсан байгууллагуудаас хүүхдийн хоногийн хоолны илчлэгтэй уялдуулж технологийн карт боловсруулан мөрдөж ажилласан МСҮТ-ийн хамгийн өндөр материалын зарцуулалттай сарын илчлэгийг тооцож үзэхэд 1 хүүхдэд өдөрт дунджаар 2347 ккал авахаас 1551 ккал бүхий хоол хүнсийг олгосон байна.

Б.2.2. Нийт хоолны зардлын 20 хувь буюу 318,5 сая төгрөгийн хэмнэлтийг бусад зардалд шилжүүлэн зарцуулж, үүний 9 хувийг зориулалт бусаар зарцуулсан байна.

Аудитад хамрагдсан байгууллагуудын хоолны зардлын нийт төсөв 2019 онд 1603,7 сая төгрөгөөр батлагдсан байна.

Тайлант хугацаанд аймгийн Засаг дарга МУ-ын Төсвийн тухай хуулийн 61.1-т заасан чиг үүргийг орон нутагт хэрэгжүүлэх үүргийн хүрээнд боловсролын салбарын байгууллагуудын төсөвт зохицуулалт хийж, хоолны зардлаас 318,5 сая төгрөгийг бусад зардалд шилжүүлэн зарцуулж, хоолны зардлын нийт гүйцэтгэл 1273,1 сая төгрөг байна.

График№5



График№6



Боловсролын салбарын байгууллагуудын 2019 оны батлагдсан төсөвт оруулсан зохицуулалтаар түүвэрт хамрагдсан 32 байгууллагын /МСҮТ хамрагдахгүй/ хоол, хүнсний зардалд өөрчлөлт оруулан, 30 байгууллагын 313.0 сая төгрөгийг хасаж, 2 байгууллагад 5.5 сая төгрөг нэмэгдүүлж зохицуулалт хийж, хоолны зардлын хэмнэлтийг бага үнэтэй, түргэн элэгдэх зүйлс, багаж, техник хэрэгсэл, тавилга аж ахуйн эд хогшил худалдан авах зардлуудыг нэмэгдүүлсэн зохицуулалт хийсэн байна.

МУ-ын Төсвийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2-т “Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ”, 45.2.1-т “Нэгжид ногдох норм, нормативаар тооцон төсвийг нь баталсан ба гүйцэтгэл нь анх тооцсон нэгжийн тоо хэмжээнээс бага бол тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ” гэсэн заалтуудыг зөрчсөн байна. МУ-ын Засгийн газрын 2012 оны 106 дугаар тогтоолоор батлагдсан хоолны зардлын норматив /цэцэрлэг-1650, дотуур байр-2315 төгрөг/ хэмжээнээс бага дүнгээр хоолны зардал зарцуулан дараах хэмнэлтийг үүсгэж, бусад зардлуудад шилжүүлэн зарцуулсан байна.

Хүснэгт№3

№	Байгууллагын нэр	Нормативаас хэмнэсэн зардлын дүн /мян.төг/
1	Даланжаргалан сумын цэцэрлэг	1,529.0
2	Дэлгэрэх сумын ЕБС дотуур байр	995.1
3	Өргөн сумын цэцэрлэг	19.5
4	Улаанбадрах сумын цэцэрлэг	238.1
5	Хатанбулаг сумын ЕБС	483.1
6	Хөвсгөл сумын ЕБС	565.9
7	Сайншанд сумын 5-р цэцэрлэг	443.8
8	Сайншанд сумын 8-р цэцэрлэг	1,344.5
9	Сайншанд сумын 9-р цэцэрлэг	1,324.6
10	Сайншанд сумын 11-р цэцэрлэг	1,416.7
11	Сайншанд сумын МСҮТ	6,473.3
12	Замын-Үүд сумын 1-р цэцэрлэг	1,838.6
13	Замын-Үүд сумын 3-р цэцэрлэг	3,772.0
14	Замын-Үүд сумын 4-р цэцэрлэг	6,437.9
15	Замын-Үүд сумын 5-р цэцэрлэг	467.5
Нийт		27,349.5

Дээрх мэдээллээс харахад байгууллагууд хоолны цэсээс шалтгаалан тогтоосон нормативыг өдөр тутам баримтлаагүй, нийт 27,3 сая төгрөгийг тогтоосон нормативаас хүүхдүүдэд дутуу олгож, хэмнэлт үүсгэсэн байх бөгөөд тус хэмнэлтээр хүүхдэд өгч байгаа хоолны орц, материалын нэр төрлийг олшруулж, илүү илчлэг хоол хүнсээр хангах боломж байсан байна.

Хоолны зардлын норматив хэмжээ нь хоногийн хоолны илчлэгийг хангахад хүрэлцэхгүй байхад дээрх байгууллагууд батлагдсан төсвийг тогтоосон хэмжээгээр бүрэн зарцуулаагүй байгаа нь боловсролын салбарын байгууллагууд хүүхдийн хоногийн хоол тэжээлээс авах илчлэгийг хангуулах, хэмжээг нэмэгдүүлэх, батлагдсан төсвийн хүрээнд нөөцийг бүрэн зохистой ашиглах талаар арга хэмжээ авч ажиллаагүй байна. Жишээ нь, Хатанбулаг сумын ЕБС-ийн дотуур байр нь хоолны зардлыг 483,1 мянган төгрөгөөр хэмнэсэн байх боловч хоолны зарцуулалтыг авч үзэхэд хүүхдэд өдөрт 2 нэр төрлийн хоол олгодог байна.

БҮЛЭГ В. Орон нутгийн удирдлага, мэргэжлийн байгууллагаас хүүхдийн хоол үйлдвэрлэлийг чанаржуулах талаар мэргэжил арга зүйгээр хангаж ажиллах шаардлагатай байна.

В.1. Хүүхдийн хоолны илчлэг, норм, орц, чанар байдалд тавих хяналт хангалтгүй байна.

В.1.1. Мэргэжлийн байгууллагуудаас хэрэгжүүлсэн хяналт шалгалтын үр дүн тодорхой бус байна.

МУ-ын Төрийн хяналт шалгалтын тухай хуульд мэргэжлийн хяналтын улсын байцаагч нь хууль тогтоомжоор болон түүнийг үндэслэн төрийн эрх бүхий байгууллагаас удирдлагын тодорхой салбарт нийтээр дагаж мөрдөхөөр тогтоосон тусгай журмын биелэлтэд хяналт тавих, хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчил дутагдлыг таслан зогсоох, түүний шалтгаан нөхцөлийг арилгах талаар холбогдох байгууллага, аж ахуйн нэгж, иргэн, албан тушаалтанд шаардлага тавьж, хугацаатай үүрэг даалгавар өгч биелэлтийг хангуулах чиг үүргийг хэрэгжүүлэхээр заасан.

Аймгийн МХГ-ын гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу 9 төрийн өмчит сургалтын байгууллагыг хамруулан зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж, шалгалтад хамрагдсан 9 объектын хоол хүнснээс авбал зохих илчлэгийн хэмжээг ЭМС-ын 2017 оны 174 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан норм хэмжээтэй харьцуулж үзэхэд 1-3 настай эрэгтэй хүүхэд 352,6 ккал, эмэгтэй 338,5 ккал, 4-6 настай эрэгтэй 228,6 ккал, эмэгтэй 136,6 ккал илчлэг тус бүр илүү, ЕБС-ийн дотуур байрны хүүхдүүд дутуу авч байгаа талаар дүгнэлт гаргажээ.

Шалгалтын дүнд үндэслэн аймгийн БСУГ-т сумдын сургууль, цэцэрлэгт эмчийн орон тоог батлуулах, эм эмнэлгийн хэрэгслийн зардлыг нэмэгдүүлэх талаар 2 зөвлөмж, сургууль, цэцэрлэгийн захирал, эрхлэгч нарт хоол үйлдвэрлэлийн байранд зохистой дадал нэвтрүүлэх, эмийн бүртгэл хөтлөх, дотоод хяналтын журмыг баталж мөрдөх, хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний ул мөрийг тогтоох бүртгэл хөтлөх гэсэн 4 зөвлөмжийг хүргүүлсэн байна.

Мөн ЭМС-ын хоногийн хоол хүнсээр авбал зохих илчлэг, үндсэн шимт бодис, амин дэм, эрдэс бодисын зөвлөмж хэмжээ баталсан тушаалуудын хэрэгжилтийг ханган ажиллахыг ЭМГ-т даалгасан байна.

МУ-ын Эрүүл мэндийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг харьяалах нутаг дэвсгэртээ зохион байгуулах эрх үүргийн хүрээнд аймгийн ЭМГ-ын даргын баталсан удирдамжийн дагуу 2019 онд Сайншанд сумын ЕБ-ын 1, 2, 3, 4, 5 дугаар сургууль, 12 цэцэрлэгийн дотуур байрны гал тогоо, хоол үйлчилгээнд 3 удаагийн дэмжлэгт хяналтыг зохион байгуулсан байна.

Хяналт шалгалтын дүнд үндэслэн технологийн картын орох орц, норм зохиоход тавигдах шаардлагыг баримтлах, давс, сахарын хэрэглээг бууруулах, хүнсний бүтээгдэхүүнийг хүлээж авахдаа хугацааг хянах, баяжуулсан бүтээгдэхүүний хэрэглээг нэмэгдүүлэх, масло тосны хэрэглээг бууруулах талаар шалгагдагч байгууллагуудад зөвлөмж хүргүүлсэн байна.

Хяналт хэрэгжүүлснээр хоол үйлчилгээний технологи карт, хоолны цэсэд өөрчлөлт оруулсан, аминдэмээр баялаг 8 төрлийн бүтээгдэхүүнийг нэмж тусгуулсан, давс, сахар, тосны хэрэглээнд анхаарснаар давсны хэмжээг өмнөх оны хэрэглээнээс 2 хувь, сахарын хэмжээг 30 хувиар бууруулсан талаар тайланд тусгажээ.

Аймгийн МХГ, ЭМГ-аас хүүхдийн хоолны илчлэг норм, эрүүл ахуйд тодорхой хэмжээний хяналт шалгалтыг явуулсан талаар тайлан мэдээ ирүүлсэн байх боловч хяналт шалгалтын дүн, зөвлөмжийг хүргүүлээгүй, шалгагдагч байгууллагууд энэ талаар мэдээлэлгүй байлаа.

В.1.2. Аймаг, сумын Засаг дарга, БСУГ-аас хүүхдийн зохистой хооллолтын талаар ажил зохион байгуулаагүй байна.

МУ-ын Боловсролын тухай хуульд аймгийн БСУГ нь боловсролын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг орон нутгийн хэмжээнд зохион байгуулах, салбарын байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт тавих, хяналт шинжилгээ хийх, аймгийн Засаг дарга нь цэцэрлэг, сургуулийг зориулалтын барилга байгууламжаар хангах, дотуур байрны хүүхдийн хоол хүнсний хангамжийг зохих журмын дагуу шийдвэрлэх бүрэн эрхийг хэрэгжүүлэхээр заасан.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд аймгийн Засаг дарга, БСУГ-ын даргад хүүхдийн зохистой хооллолтын талаар хэрэгжүүлсэн ажлын тайлан, бусад холбогдох материалыг ирүүлэх тухай албан тоот хүргүүлсэн боловч материал ирүүлээгүй болно.

БСУГ-ын холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх явцад салбарын байгууллагуудад зөвлөн туслах хяналт шалгалтыг хэрэгжүүлсэн боловч зөвлөмжийг албан тоотоор хүргүүлээгүй, тухайн үед аман байдлаар зөвлөдөг тухай тайлбар өгсөн.

В.2. Хүүхдийн хоолны илчлэг, норм, орц, чанар байдлыг сайжруулах талаар хийх ажлын чиглэл тодорхойгүй байна.

В.2.1. Мэргэжлийн байгууллагууд хяналт шалгалт хийж байгаа боловч үр дүнг сайжруулах чиглэл өгөөгүй байна.

Аймгийн мэргэжлийн байгууллагуудаас тодорхой хяналт шалгалтыг зохион байгуулж, хяналтаар илэрсэн зөрчилд зөвлөмж хүргүүлэн, хяналт тавьж ажилласнаар нийт зөрчлийн 95,2 хувийг арилгуулсан талаар тайланд дурдсан байх боловч шалгагдагч байгууллагуудад хяналт шалгалтын тайлан, хэрэгжүүлэх зөвлөмжийг албан тоотоор хүргүүлээгүй байна.

Харин аудитад хамрагдсан байгууллагууд дотоод хяналт шалгалт хэрэгжүүлэх төлөвлөгөөнд хоолны илчлэг норм, эрүүл ахуйн байдалд хяналт тавихаар тусгасан боловч хэрэгжүүлсэн ажлын талаар тодорхой тусгаагүй байна.

В.2.2. Хүүхдийн хоолны орц, хоногт авах илчлэгийн асуудлаар эцэг, эхчүүдээс санал, гомдол ирүүлээгүй байна.

Аудитын гүйцэтгэлийн үе шатанд аудитад хамрагдсан байгууллагуудын өргөдөл гомдлын бүртгэлийг авч үзэхэд хүүхдийн хоолны орц, хоногт авах илчлэгийн асуудлаар санал гомдол ирүүлээгүй байна.

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

МУ-ын ЗГ-ын баталсан хоолны зардлын норматив нь зах зээлийн бодит үнэ ханштай уялдаагүй батлагдсанаас МСҮТ, ЕБС-ийн дотуур байр, цэцэрлэгийн хүүхдийн хоолны илчлэг нормыг бүрэн хангах нөхцөл бүрдэхгүй байна.

Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний үнийн өсөлт 2012 оноос хойш 43-107,8 хувийн өсөлттэй байхад хоолны зардлын шинэчилсэн нормативыг 50 хувиар нэмэгдүүлж тогтоосон байна.

Хоолны илчлэг норм тогтоосон ЭМС, БСШУСС, хамтарсан тушаалуудаар баталсан журмуудыг мөрдөх талаар тодорхой чиглэлгүй байгаагаас боловсролын салбарын байгууллагууд хоолны үйлчилгээнд хүнсний бүтээгдэхүүнийг харилцан адилгүй хэмжээгээр зарцуулж байна.

Технологи картыг хоногийн хоол хүнсээр авбал зохих үндсэн шимт бодисын зөвлөмжтэй уялдуулж, илчлэгийг хангахуйц байдлаар боловсруулаагүй, хоолны цэсэд үндэслэж материалын нийлүүлэлтийг тооцоолоогүй, зарим байгууллагууд хоолны үйлчилгээнд технологи картыг боловсруулж мөрдөөгүй байна.

ЕБС, цэцэрлэгүүд нь тухайн хичээлийн жилийн батлагдсан хоолны зардлаар худалдан авах хүнсний бүтээгдэхүүний тоо хэмжээг тооцохдоо хоол хүнсээр авбал зохих илчлэг үндсэн шимт бодисын хэмжээг хангахад хүрэлцэх талаар тооцож төлөвлөдөггүй байна.

Хоол хүнсний хэрэгцээт материалын нэр төрөл, тоо хэмжээнд үндэслэхгүй зөвхөн батлагдсан төсвийн хэмжээгээр худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна.

Бараа бүтээгдэхүүн худалдах, худалдан авах гэрээнд бүтээгдэхүүний үнийг тодорхой тусгаагүйгээс хичээлийн жилийн явцад бараа бүтээгдэхүүний үнийг нэмэгдүүлж нийлүүлэгдсэн байна.

Тухайн өдрийн хоолны материалыг олгохдоо ангиудын ирцийн үнэн зөв байдал, цэсэд тусгагдсан хоолны нэр төрөл, технологийн картад тусгасан материалын хэмжээг уялдуулж зарцуулаагүй, шат шатны хяналтыг хэрэгжүүлээгүй байна.

Нэг хүүхдэд ногдох норматив зардлыг хэтрүүлэн зарцуулсан байна.

Хүүхдийн хоолонд төрөл бүрийн бэлэн бүтээгдэхүүнийг өдөр тутмын хүнсэнд тогтмол хэрэглэдэг байна.

Батлагдсан хоолны зардлын төсвийн 20 хувь буюу 318,5 сая төгрөгийг хэмнэж, үүнээс 9 хувь буюу 27,3 сая төгрөгийг тогтоосон нормативаас бага хэмжээгээр зарцуулж хэмнэлт үүсгэн зориулалт бусаар зарцуулсан байна.

Мэргэжлийн байгууллагуудаас боловсролын салбарын байгууллагуудын хоолны үйлчилгээ, илчлэг нормын байдалд тодорхой хяналт шалгалт хийсэн боловч шалгалтын үр дүн, зөвлөмжийг шалгагдагч байгууллагуудад хүргүүлээгүйгээс үр дүн гараагүй байна.

Аудитаар нийт 360,6 сая төгрөгийн зөрчил илрүүлж, холбогдох албан тушаалтнуудад 11 зөвлөмж хүргүүллээ.

ЗӨВЛӨМЖ

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ УЛАМЖЛАХ НЬ:

1. Хүүхдийн хоолны хэрэгцээт илчлэг, хоногийн хоолны хэмжээ, хоногийн хэрэгцээг хангах бүтээгдэхүүний жишгийг баталсан ЭМС-ын 2013 оны 207, 2014 оны 113, 2017 оны 74 дүгээр тушаалууд, БСШУСС, ЭМС-ын хамтарсан 2018 оны А/448, А/268 хамтарсан тушаалуудыг хуульд нийцүүлэн нэгтгэж оновчтой байдлаар боловсруулан баталж, боловсролын салбаруудын байгууллагуудад баримтлах журмыг тодорхой болгох талаар уламжилж өгнө үү.
2. Хүүхдийн хоолны зардлын норматив хэмжээг зах зээлийн бодит үнэ ханштай уялдуулж тогтоолгох талаар эрх бүхий байгууллагад уламжилж өгнө үү.

САЙНШАНД СУМЫН ЗАСАГ ДАРГАД:

1. Сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа боловсролын салбарын байгууллагуудын хоол, хүнсний материалын худалдан авах үйл ажиллагааг зохион байгуулахдаа захиалагч байгууллагуудаас ирүүлсэн хэрэгцээт материалын нэр төрөл, тоо хэмжээнд үндэслэх.
2. Тендерт шалгарсан нийлүүлэгчтэй байгуулах гэрээнд барааны үнийг хатуу тогтоож, гэрээний үүргийн биелэлтийг хангуулах, нийлүүлж байгаа бүтээгдэхүүний чанар байдалд анхаарч, захиалагчийн хичээлийн жилд норматив зардалд багтаан хоолны зардлын батлагдсан төсвийг тогтмол үнээр, зохистой зарцуулах нөхцөлийг бүрдүүлэх.

БОЛОВСРОЛ, СОЁЛ УРЛАГИЙН ГАЗАРТ:

1. Хүүхдийн хоолны зардлын норматив хэмжээг зах зээлийн бодит үнэ ханштай уялдуулж тогтоолгох талаар тооцоо судалгааг орон нутгийн хэмжээнд хийж, холбогдох эрх бүхий албан тушаалтанд уламжлан, шийдвэрлүүлэх арга хэмжээ авч ажиллах.
2. Боловсролын салбарын байгууллагуудад МУ-ын Засгийн газрын 311 дүгээр тогтоолоор батлагдсан журмын дагуу хүүхдийн хоолны эрүүл ахуй, илчлэг нормд тавих дотоод хяналтыг чанартай зохион байгуулж, мэргэжлийн байгууллагуудаас мэргэжил, арга зүйн зөвлөгөө авч ажиллах.
3. Хийсэн хяналт шалгалтын үр дүнг шалгадагч байгууллагуудад тогтмол танилцуулах, хяналтын тайлан, зөвлөмжийг албан бичгээр хүргүүлж, зөрчлийг арилгасан талаар биелэлтийг баримтжуулах.
4. Технологи картыг хоногийн хоол хүнсээр авбал зохих үндсэн шимт бодисын зөвлөмжтэй уялдуулж, илчлэгийг хангахуйц байдлаар боловсруулж батлах, цэсэд технологи картаар батлагдсан хоол хүнсийг тусгаж мөрдөх.

5. Тухайн хичээлийн жилийн батлагдсан хоолны зардлаар худалдан авах хүнсний бүтээгдэхүүний тоо хэмжээг хоол хүнсээр авбал зохих илчлэг үндсэн шимт бодисын хэмжээнд үндэслэж тооцох.
6. Өдөр тутмын хоолны материалыг хоолны цэсэд тулгуурлан, технологийн картад тусгагдсан хэмжээгээр, тухайн өдрийн хүүхдийн бодит ирцэд үндэслэн олгож байгаа эсэхэд тогтмол хяналт тавьж ажиллах.
7. Хүүхдийн хоолны зардлын нормативыг баримталж, батлагдсан төсвийг бүрэн зарцуулах, тогтоосон хэмжээнээс хэтрүүлэн зарцуулахгүй байх, .
8. Хүүхдийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд хориглосон бүтээгдэхүүнийг ашиглахгүй байх, бэлэн бүтээгдэхүүний өдөр тутам хэрэглэх хэмжээг багасгах.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАРТ:


1. Хийсэн хяналт шалгалтын үр дүнг шалгадагч байгууллагуудад тогтмол танилцуулах, хяналтын тайлан, зөвлөмжийг албан бичгээр хүргүүлж, зөрчлийг арилгасан талаар биелэлтийг баримтжуулах.

МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ГАЗАРТ:

1. Хийсэн хяналт шалгалтын үр дүнг шалгадагч байгууллагуудад тогтмол танилцуулах, хяналтын тайлан, зөвлөмжийг албан бичгээр хүргүүлж, зөрчлийг арилгасан талаар биелэлтийг баримтжуулах.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ч.АРИУНАА



ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГААС ИРҮҮЛСЭН САНАЛ



ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР

44105 Дорноговь аймаг, Сайншанд сум, 2 дугаар баг,
Утас/факс: (705) 2-23-49
И-мэйл: emg.dornogovi@gmail.com

2020.06.29 № 769
танай 2020.06.26-ны № 46/503-т

ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА
Ч.АРИУНАА ТАНАА

Санал хүргүүлэх тухай

Танай аудитын газраас ирүүлсэн "МСҮТ, ЕБС-ийн дотуур байр, цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлын зарцуулалт, үр дүн" сэдэвт нийцлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Манай байгууллага нь Эрүүл мэндийн тухай хуулийн 12-р зүйлд заасан чиг үүргийг хэрэгжүүлэн, хүүхдийн байгууллагуудад дэмжин туслах үүрэгтэй ажилладаг.

Ажил үүргийнхээ дагуу ерөнхий боловсролын сургуулийн үдийн цай, дотуур байр, цэцэрлэгийн хүүхдийн хоол үйлчилгээнд дэмжлэгт хяналт хийх бүртээ байгууллагын дарга нарт алдаа дутагдал, ажил сайжруулах чиглэл өгч арга зүйгээр хангадаг.

2019 онд Наран өргөө цэцэрлэгийн хүүхдийн хоол үйлчилгээнд хийгдсэн дэмжлэгт хяналтын зөвлөмжийг Эрүүл мэндийн газрын даргын 2019 оны 09 сарын 09-ны өдрийн 913, ерөнхий боловсролын 1-р сургуулийн үдийн цай, дотуур байрны дэмжлэгт хяналтын зөвлөмжийг 2019 оны 10 сарын 28-ны өдрийн 1119, ерөнхий боловсролын 2-р сургуулийн үдийн цайны дэмжлэгт хяналтын зөвлөмжийг 2019 оны 10 сарын 28-ны өдрийн 1120, ерөнхий боловсролын 3-р сургуулийн үдийн цай, дотуур байрны дэмжлэгт хяналтын зөвлөмжийг 2019 оны 10 сарын 28-ны өдрийн 1121, ерөнхий боловсролын 5-р сургуулийн үдийн цайны дэмжлэгт хяналтын зөвлөмжийг 2019 оны 10 сарын 28-ны өдрийн 1122 албан тоотоор тус тус хүргүүлсэн.

Цаашид өгсөн зөвлөмжийн биелэлтэнд хяналт тавьж ажиллах болно.



ДАРГА

Г.ЭНХЦЭЦЭГ



ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ГАЗАР

44105 Дорноговь аймаг, Сайншанд сум, 2 дугаар баг,

Утас: (705) 2-23-52

2020.06.30 № 3/382
танай 2020.06.26-ны № 1-6/508-т

Санал хүргүүлэх тухай

Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын “МСҮТ, ЕБС-ийн дотуур байр, цэцэрлэгийн хүүхдийн хоолны зарцуулалт, үр дүн” сэдэвт нийцлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцав.


Тайлангийн төсөлд аймгийн боловсрол соёлын газарт дараах санал хүрүүлж байна. Үүнд:

Сургалтын байгууллага нь Монгол Улсын Засгийн газрын 311 дүгээр тогтоолоор батлагдсан журмыг үндэслэн дотоод хяналтын ажилтан гэх албан тушаалтанг томилон ажиллуулдаг.

Уг албан тушаалтан байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад хөндлөнгийн хараат бус байж, хүүхдийн эрүүл аюулгүй орчинд суралцах бүхий л үйл ажиллагааг хууль, дүрэм журам стандартын шаардлагад нийцэж байгаа эсэхэд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах бүрэн эрх нь тусгагдсан байдаг.

Иймд дотоод хяналтын тайлан мэдээнд тухайлбал хоол хүнсний эрүүл ахуй, чанар аюулгүй байдалд илэрч байгаа нийтлэг дутагдлын талаар улирал, жил бүр тусгаж, холбогдох эрх бүхий төр захиргааны байгууллагад мэдээллэж, мэргэжил арга зүйн зөвлөгөө авах чиглэлээр хамтран ажиллах шаардлагатай байна.

ДАРГА



М.МӨНХБАЯР



ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ,
БОЛОВСРОЛ, СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗАР

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум, 3 дугаар баг,
Утас: (705) 2-39-77, факс: (705) 2-36-77,
Бүх сайт: dornogovi@mecs.gov.mn

2020.07.02 № 179

танай 2020.06.80 -ны № 16/506 -т

ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Ч.АРИУНАА ТАНАА

Санал хүргүүлэх тухай

Тухай онуудад мөрдөгдөж байсан “Хоолны норматив тогтоосон 106-р тогтоол нь 2012 онд гарсан. Тухай үеийн үнэ ханш барааны үнэ тариф одооны үнэ тариф харьцангуй ялгаатай. Төрөөс төрийн албан хаагчдын цалинг нэмсэн, гэвч тухайн цалингийн өсөлттэй уялдан барааны үнэ тариф өссөн. Тухайн цэцэрлэгийн хүүхдийн хоолны гүйцэтгэл нь өвчтэй, чөлөөтэй тасалсан хүүхдийн тоогоор хоолны зардал хэмнэгддэг. Хоолны зардал хэмнэсэн гээд хүүхдийн хоолны норматив 1650 төгрөгийг нэмэгдүүлэх боломжгүй Хоолны зардлын хувьд хувьсах зардлаар хуваарилалт хийхэд бодит байдалд нийцэхгүй яагаад гэвэл удаа дараа цалингийн өсөлт нэмэгдсэн, барааны үнэ тариф нэмэгдсэн байхад норматив суурилах үнэн бодит биш. Жнь.Өнөөдөр хойнны мах 8000 төгрөг үхрийн мах 10000 төгрөг байна Хоолны норматив 1650 төгрөг гээд бодоход барааны үнэ тарифаас шалтгаалан хоолны орцын хэдэн хувь илчлэг байх вэ талаар дээд шатны байгууллагадаа саналыг хүргүүлж байсан.


БСШУСЯам доод шатнаас ирүүлсэн саналуудыг үндэслэн хоолны нормативыг өөрчлөх талаар саналыг боловсруулан хүргүүлснээр 2019 оны 12 сарын 18-ны өдрийн “Хоолны зардлын норматив тогтоох тухай” 450 дугаар тогтоолоор цэцэрлэгийн хүүхэд бүрийн нэг өдрийн хоолны зардлыг 8-10 цагаар ажилладаг цэцэрлэгт 2475 төгрөгөөр тогтоосон.

Цэцэрлэгийн хоолны цэсийг бага насны хүүхдийн бие махбодийн онцлог, хэрэгцээнд нийцүүлэн нэр төрлийг олшруулах, хоолны чанарыг сайжруулахад анхаарч ажиллах чиглэлийг хүргүүлсэн. Мөн хүүхдийн ирцийг тогтмол авч тухайн нэгжид ажиллахдаа бодит ирцтэй тулгах ажлыг тогтмолжуулсан.

Хүүхдийн хоногийн хоолны норм, үндсэн шимт бодис, илчлэгийн хэрэгцээг батлах талаар: Монгол Улсын Эрүүл мэнд сайд, Боловсрол соёл шинжлэх ухааны сайдын хамтарсан 2005 оны 225/296 тоот тушаалаар баталсан” 1-19 насны хүүхдийн хоногийн хоолны норм, үндсэн шимт бодис, илчлэгийн хэрэгцээг батлах тухай журам, Эрүүл мэндийн сайдын 2014 ны 113 тоот тушаалаар баталсан Монгол хүүхдийн хоол тэжээлийн бодисуудын зөвлөмж хэмжээг батлах тухай тушаал журмуудын алийг нь баримтлан ажиллах талаар хариуг авахаар БШУСЯ-нд 2020 оны 02 сарын 19-ны өдрийн 56 дугаар албан бичгээр хүргүүлсэн болно.

ДАРГА

Ч.ОТГОНБАЯР



ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛД ӨГСӨН ТАЙЛБАР

Мэргэжлийн хяналтын газраас ирүүлсэн саналд:

- Боловсролын салбарын байгууллагуудад МУ-ын Засгийн газрын 311 дүгээр тогтоолоор батлагдсан журмын дагуу хүүхдийн хоолны эрүүл ахуй, илчлэг нормд тавих дотоод хяналтыг чанартай зохион байгуулж, мэргэжлийн байгууллагуудаас мэргэжил, арга зүйн зөвлөгөө авч ажиллах талаарх зөвлөмжийг БСУГ-т хүргүүлэхээр аудитын тайланд тусгалаа.

АУДИТЫГ ГҮЙЦЭТГЭСЭН БАГИЙН ГИШҮҮД:

ГҮЙЦЭТГЭСЭН:

АХЛАХ АУДИТОР



Э.ЭНХЦЭЦЭГ

АУДИТОР



Л.РАВДАНДОРЖ


ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР



Ч.ХЭРЛЭНЧИМЭГ

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.АРИУНАА



АУДИТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХАМТРАН ОРОЛЦСОНД
ТАЛАРХАЛ ИЛЭРХИЙЛБЕ.



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ**

2020 оны 07 сарын 02 өдөр

Дугаар А/12

Дорноговь аймаг, Сайншанд сум

Нийцлийн аудитын тайлан
баталгаажуулах тухай

Төрийн Аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 20 дугаар зүйлийн 20.2, 20.3, 21 дүгээр зүйлийн 21.1, Монгол улсын Ерөнхий аудиторов 2016 оны А/95 тоот тушаал, 2016 оны А/146 тоот тушаалаар батлагдсан "Нийцлийн аудитын түр журам"-ын 9 дүгээр зүйлийн 9.2 дахь заалт, 2018 оны А/207 тоот тушаалын 5 дугаар хавсралтын 2.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "МСҮТ, ЕБС-ийн дотуур байр, цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлын зарцуулалт, үр дүн" сэдэвт нийцлийн аудитын тайланг баталгаажуулсугай.
2. Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, үр дүнг 2020 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлэхийг аймгийн БСУГ, МХГ, ЭМГ, Сайншанд сумын Засаг дарга нарт тус тус зөвлөсүгэй.
3. Аудитын тайланг аймгийн ИТХ-ын даргад хүргүүлсүгэй.
4. Зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер /Ч.Хэрлэнчимэг/-т үүрэг болгосугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Ч.АРИУНАА

010010020